Хилийн боомтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Хилийн боомын захиргааны даргын 2022 оны 12 дугаар сарын 27-ны А/33 тоот тушаалаар бэлтгэсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрддөг, тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хилийн боомын захиргааны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,004,299.2 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 363,100.0 | - | (363,100.0) |
| Авлага | 17,655.8 | 17,655.8 | - |
| Урьдчилгаа | - | 629,300.0 | 629,300.0 |
| Бараа материал | 531,854.9 | 437,505.7 | (94,349.2) |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 3,663,100.0 | 560,347.6 | (3,102,752.4) |
| Үндсэн хөрөнгө | 30,935,290.4 | 34,870,491.2 | 3,935,200.8 |
| **Нийт хөрөнгө** | **35,511,001.1** | **36,515,300.3** | **1,004,299.2** |
| Өр төлбөр | 363,100.0 | 320,202.2 | (42,897.8) |
| Өмнөх үеийн үр дүн данс | 35,147,901.1 | 36,195,098.1 | 1,047,197.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **35,511,001.1** | **36,515,300.3** | **1,004,299.2** |

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 363,100.0 мянган төгрөгөөр буурсан нь Дорноговь аймгийн Замын-Үүд суманд 30 айлын ажилчдын орон сууцны барилгын санхүүжилтийн барьцаа хөрөнгө болох 363,100.0 мянган төгрөгийг тайлант хугацаанд олгосонтой холбоотой.
- Урьдчилгаа дансны үлдэгдэл 629,300.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Буйр нуурын усан замын боомтын техник эдийн засгийн үндэслэл болон зураг төслийн ажлыг гүйцэтгэхээр 899,000.0 мянган төгрөгийн гэрээг байгуулан ажиллаж, гэрээт ажил дуусаагүй байгаатай холбоотой;
- Бараа материалын үлдэгдэл 94,349.2 мянган төгрөгөөр буурсан нь 487,663.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 583,067.7 мянган төгрөгийн зарцуулалт хийгдсэнээс үлдэгдэл буурсан;

- Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 3,102,752.4 мянган төгрөгөөр буурсан нь тус дансанд бүртгэлтэй байсан Замын-Үүд дэх гаалийн ажилчдын 3,663,100.0 мянган төгрөгийн өртөгтэй байр ашиглалтад орсонтой холбоотой үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлэн бүртгэснээс голлон нөлөөлжээ. Тус дансны үлдэгдэлд Гашуун сухайт боомтын гаалийн лабораторийн засвар тохижилттой холбоотой 560,347.6 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна;
- Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 4,359,490.1 мянган төгрөгөөр өссөн нь Замын-Үүд боомтод байрлах Гаалийн ажилчдын 30 айлын орон сууцны барилгыг үндсэн хөрөнгөд бүртгэж, хөрөнгө оруулалтын арга хэмжээний хүрээнд 5,247,014.2 мянган төгрөг, үнэ төлбөргүйгээр шилжиж ирсэн 2,048,748.8 мянган төгрөгийн хөрөнгөөр  нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрүүдээр Сангийн яаманд 80,589.4 мянган төгрөг, Эрүүл мэндийн яаманд 1,000,815.9 мянган төгрөг, Хилийн боомтын хөгжлийн корпорацад 52,624.5 мянган төгрөг, Хилийн үр ашиг нэмэгдүүлэх тогтвортой хөгжил төсөлд 22.423.5 мянган төгрөг, Гаалийн байгууллагуудад 60,470.1 мянган төгрөг, Хилийн цэрэгт 185,540.5 мянган төгрөг, Гадаадын иргэн харьяатын газарт 8,490,0 мянга, Үндэсний урлагийн их театрт 160,000.0 мянган төгрөгийн бүгд 1,571,043.9 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, 4,906,790.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал  тайлагнасантай холбоотой байна;
- Өр төлбөрийн дансны үлдэгдэл 42,897.8 мянган төгрөгөөр буурсан нь гэрээний гүйцэтгэл дууссан аж ахуйн нэгжүүдэд барьцаа төлбөрийн өр төлбөрийг олгосон холбоотой;
- Өмнөх үеийн үр дүн данс 1,047,197.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс нөлөөлсөн байна.

Биет бус хөрөнгөд 119,117.3 мянган төгрөгийн дараах хэрэглээний программууд бүртгэлтэй байна. Үүнд:

- Санхүүгийн үйл ажиллагааны 880.0 мянган төгрөгийн өртөгтэй Acoulus санхүүгийн программ;
- Шуурхай системийн 9,240.0 мянган төгрөгийн өртөгтэй программ;
- Архивын үйл ажиллагааны 16,586.0 мянган төгрөгийн өртөгтэй программ;
- Байгууллагын 18,700.0 мянган төгрөгийн Вэб сайт;
- Байгууллагын дотоод сүлжээний аюулгүй байдлыг хангах зориулалттай 11,690.0 мянган төгрөгийн лиценз;
- Гаалийн хяналтын үйл ажиллагааны 21,716.2 мянган төгрөгийн камерын лиценз;
- Виртуал серверийн 5,744.0 мянган төгрөгийн үйлдлийн системийн лиценз;
- Мөн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 34,561.1 мянган төгрөгийн хэрэглээний программууд байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 16,866,862.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс 3,329,856.5 мянган төгрөгийн зардлыг бууруулан 13,537,005.5 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь тайлант онд хөрөнгө оруулалтын арга хэмжээний зардлыг бууруулах, дараа онд хэрэгжүүлэхээр шилжүүлэх, төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу нөөц бүрдүүлэх эрсдэл зэргийн тооцон зардлыг бууруулсантай холбоотой байна.

Тайлант оны батлагдсан төсвийг цалингийн зардлаас 250,590.2 мянган төгрөг, байр ашиглалт хангамжийн зардлыг 351,563.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил болон эд хогшил худалдан авах зардлуудыг 233,830.5 мянган төгрөг, хөрөнгийн зардлыг 520,437.4

мянган төгрөг, нийт 1,356,421.3 мянган төгрөгөөр бууруулж 12,180,584.2 мянган төгрөгөөр тодотгосон байна.

Тайлант жилийн эцэст урсгал санхүүжилтийг 4,214,450.1 мянган төгрөг, хөрөнгийн зардлыг 6,198,500.0 мянган төгрөг, нийт 10,412,950.1 мянган төгрөгийг зарцуулахаар төсвийн хуваарийг шинэчилсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 10,412,950.1 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 9,658,304.3 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч 9,293,789.9 мянган төгрөгийг зарцуулж 364,514.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 9,293,789.9 мянган төгрөг буюу 89.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 158,741.3 мянган төгрөг, ажил олгогчоос олгох шагнал, урамшууллын зардлыг 8,933.1 мянган төгрөг, бусад зардал буюу хөрөнгө оруулалтын зардлыг 951,485.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 71106-Хилийн боомтын үйлчилгээ | | 10,412,950.1 | 9,293,789.9 | 1,119,160.2 | 89.3 |
| 1 | 80101-Үндсэн үйл ажиллагаа | 4,082,084.2 | 3,923,342.9 | 158,741.3 | 96.1 |
| 2 | 80802-Ажил олгогчоос олгох шагнал, урамшуулал | 132,365.9 | 123,432.8 | 8,933.1 | 93.2 |
| 3 | 80918- хөрөнгийн зардал | 6,198,500.0 | 5,247,014.2 | 951,485.8 | 84.6 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

- Тус байгууллагын батлагдсан орон тоо 52 байснаас Боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргын 2025 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн А/14 тоот тушаалаар бүтцийн өөрчлөлт хийгдэж 5 албан хаагч чөлөөлөгдөж, 21,914.0 мянган төгрөг, Сангийн сайдын 2025 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 170 тоот тушаалаар Хилийн боомтын захиргааны бүтэц, орон тоог шинэчлэн баталж, 7 албан хаагчийг чөлөөлж 54,862.0 мянган төгрөг нийт 76,776.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлаас гаргасан;
- Тус газрын даргын 2025 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн А/03 тоот тушаалаар ажлын нэг өдрийн хоолны нөхөх төлбөрийг 15.0 мянган төгрөг, унааны нөхөх төлбөрийг 5.0 мянган төгрөг болгон баталснаар 191,480.1 мянган төгрөг зарцуулж, батлагдсан төсвөөс 38,589.1 мянган төгрөг илүү зарцуулсан боловч цалингийн зардал нийт дүнгээр 172,985.3 мянган төгрөгийн хэмнэлттэй байна;
- Тайлант онд гадаад томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардал 21,656,2 мянган төгрөгөөр хэтэрсэн нь Монгол-Хятадын хилийн боомтын хөгжил, менежмент, дэд бүтэц, боомтын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 19 удаагийн, Оросын Холбооны Улсын холбогдох байгууллагуудтай хилийн боомтын хөгжил, тээвэр, логистик, бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд 9 удаагийн уулзалт, хурлыг зохион байгуулах шаардлага үүссэнтэй холбоотой хэтэрсэн;
- Тайлант онд сургалт семинарын зардалд нийт 3,100.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас “Авлигын гэмт хэргийн хуульчлагдсан байдал, “Төрийн албан хаагчийн ёс

зүйн хууль тогтоомж”, “Экспорт, импортын хөдөө аж ахуй, хүнсний бүтээгдэхүүний хяналт шалгалт, хорио цээрийн стандарт”-ын сургалтад ажилчдыг хамруулан 3,100.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

- Судалгаагаар 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 17,655.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг 2023 онд байгууллагаас төлж барагдуулан, Иргэний хэргийн шүүхэд хандсан байна. Санхүүгийн тайланд буруутай этгээдэд авлага үүсгэн бүртгэсэн.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 45,637.3 мянган төгрөгийг бүрдүүлж, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 30,715.0 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 728.9 мянган төгрөгийг зарцуулж, 14,193.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### 3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Буйр нуурын усан замын боомт байгуулах судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Зүүн бүс/-ийн арга хэмжээний хувь гэрээний хугацааг 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдөр эцсийн тайлангаа хүлээлгэн өгч дуусгахаар байгуулсан тул тайлант оны хугацаанд явцын тайланг дүгнэж 70 хувийн гүйцэтгэлийг шилжүүлсэн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр, арга хэмжээний нэр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Гашуунсухайт боомтын салбар лабораторийн зориулалтыг өөрчлөх зураг төсөв, магадлал хийлгэх, өөрчлөлтийн дагуу хийгдэх засварын ажил | 2025 он | Хилээр нэвтрэх ачаа барааны нэр, төрөл нэмэгдэнэ. /хүнс, химийн/ | 100 хувь | 1,000,000.0 | 945,827.7 |
| 2 | Шуурхай хяналтын төвийн засвар, тохижилт | 2025 он | Шуурхай зохион байгуулалтын арга хэмжээг авч Хилийн тухай хуулийн 29.13 дахь заалтын хэрэгжилт хангагдана. | 100 хувь | 250,000.0 | 191,804.5 |
| 3 | Шуурхай хяналтын төвийн техник худалдан авах | 2025 он | Шуурхай зохион байгуулалтын арга хэмжээг авч Хилийн тухай хуулийн 29.13 дахь заалтын хэрэгжилт хангагдана. | 100 хувь | 160,000.0 | 155,925.8 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Гашуунсухайт боомтын салбар лабораторийн барилгын тоноглол хэрэгсэл | 2025 он | Хилээр нэвтрэх ачаа барааны нэр, төрөл нэмэгдэнэ. /хүнс, химийн/ | 100 хувь | 860,900.0 | 764,644.5 |
| 5 | Тээврийн хэрэгсэл /туулах чадвар сайтай/ | 2025 он | Орон нутагт ажиллаж байгаа алба хаагчдын ажиллах нөхцөл сайжирч, төрийн ажил шуурхай явагдана. | 100 хувь | 640,000.0 | 640,000.0 |
| 6 | Трактор /боомтын засвар үйлчилгээ, тохижилтод зориулан аж ахуйн албанд/ | 2025 он | Боомтын цогцолборын байгууламжийн арчилгаа, болзошгүй эрсдэлээс сэргийлэх | 100 хувь | 334,200.0 | 287,100.0 |
| 7 | Гашуунсухайт боомтын Гаалийн ажилчдын орон сууцны тохижилт | 2025 он | Орон нутагт ажиллаж байгаа алба хаагчдын ажиллах нөхцөл сайжирна. | 100 хувь | 860,900.0 | 764,644.5 |
| 8 | Цахилгаан үүсгүүр /500 ква нөөц генератор/ | 2025 он | Хилийн боомт эрчим хүчний доголдолгүй байнгын ажиллагаатай байна. | 100 хувь | 760,000.0 | 608,000.0 |
| 9 | Хилийн боомт орчмын бүсийн гэрэлтүүлэг, хаягжилт | 2025 он | Хилийн боомтоор үйлчлүүлэх иргэдийн болзошгүй эрсдэл, аюулгүй байдал хангагдана. | 100 хувь | 600,000.0 | 561,565.1 |
| 10 | Буйр нуурын усан замын боомт байгуулах судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Зүүн бүс/ | 2025-2026 | Усан замын тээвэр, хил орчмын аялал жуулчлал хөгжинө. | 70 хувь | 1,100,000.0 | 629,300.0 |

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8,098,520.0 мянган төгрөг, урсгал зардлаас 1,246,100.0 төгрөг, нийт 9,344,620.0 мянган төгрөгөөр баталсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 8,098,520.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтыг Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан 1,246,100.0 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зардалд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 767,000.0 мянган төгрөгийн 4 тендер, шууд худалдан авалтын аргаар 479,100.0 мянган төгрөгийн худалдан авалт хийхээр тусгасан байна. Гүйцэтгэл 834,858.6 мянган төгрөг буюу 67.0 хувь байгаа нь Төсвийн хэмнэлттэй холбоотойгоор 250,650.0 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний зардал хасагдсантай холбоотой байна.

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хилийн боомтын захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мишээл-Од Аудит ХХК-ийн ахлах аудитор М.Цэнд-Аюуш, аудитор П.Энхцэлмэг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Т.Одончимэг, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Нямцэцэг, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хилийн боомтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 26/46 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн 2024 оны нийт зардлын 10,348,007.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 103,480.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Хилийн боомтын захиргаа нь батлагдсан төсвөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 185,800.6 мянган төгрөгөөр хэмнэсэн нь батлагдсан орон тоог 5 хүнээр бууруулан 2 удаа бүтцийн өөрчлөлт хийснээр сул орон тооны цалингийн хэмнэлт үүссэн. Мөн Үндэсний аудитын газрын өгөгдсөн зөвлөмжийн дагуу хоол хүнсний эдийн засгийн ангиллаас гарах зардлыг 7,014.8 мянган төгрөгөөр хэмнэсэн зэрэг арга хэмжээ авч ажилласан ба хуулийн хэрэгжилтийн хүрээнд хязгаарласан 32 заалтуудыг хамруулан горим сорил хэрэгжүүлэхэд хуулиар хязгаарласан зардлыг санхүүжүүлж, тайлант онд 57 ширхэг 10,296.4 мянган төгрөгийг ноолууран цамц, ороолт, малгай зэрэг бэлэг дурсгалын зүйл худалдан авахад зарцуулсан зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж байгаа болно.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 2,358,798.5 мянган төгрөгийн зөрчилд 1 хариуцлага тооцох албан шаардлага, худалдан авах ажиллагаатай холбоотой 1 зөрчилд зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх 153 мэдээллээс 113 мэдээллийг хуулийн хугацаанд, 15 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн ба 25 мэдээллийг мэдээлээгүй байна.

Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 231,799.3 мянган төгрөгийн зарлагын 2 гүйлгээг мэдээлээгүй, 1,233,609.6 мянган төгрөгийн орлогын 7 гүйлгээ, 893,389.6 мянган төгрөгийн зарлагын 57 гүйлгээг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.10 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй ажилтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нээлттэй тендер сонгон шалгаруулалтын үнэлгээний хороо тушаалын дагуу хурал зохион байгуулж тендерийн баримт бичиг боловсруулж, зарлах байтал хуралдаагүй, ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл үйлдээгүй, гэрээ байгуулахдаа огноог тодорхойлоогүй, тендерийн баримт бичгийг хуулийн дагуу архивлаагүй зэрэг зөрчилтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана", 48 дугаар зүйлийн 48.4 "Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдүүлж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана", 50 дугаар зүйлийн 50.2 "Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 50.2.1 “тендер шалгаруулалтын баримт бичиг, зарлал, урилга боловсруулах, тендер хүлээн авах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Тендерийн баримт бичгийг хуулийн дагуу бүрдүүлдэггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, өмнөх оны зөвлөмжийн биелэлт, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, цалин хөлс, татварын бүртгэл, өглөг, авлагын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулла. Завсрын аудитаар 4,978,328.2 мянган төгрөгийн 9 алдааг залруулсан.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 17,500.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1,266,933.3 мянган төгрөгийн 5 зөрчлийг арилгах албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 4,132,949.6 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгснөөс тайлант онд 17,500.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 41,641.6 мянган төгрөгийн 3 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 17,500.0 | - | - | - |
| Албан шаардлага | 6 | 1,266,933.3 | 3 | 1,225,291.7 | 50.0 |
| Зөвлөмж | 4 | 4,132,949.6 | 4 | 4,132,949.6 | 100.0 |
| **Нийт дүн** | **11** | **5,417,382.9** | **7** | **5,358,241.3** | **63.6** |

Өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй дараах зөрчлүүдийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

- "Блэссэд софтвейр ХХК-тай Вебсайт хөгжүүлэх зөвлөх үйлчилгээний 17,500.0 мянган төгрөгийн гэрээг байгуулсан боловч гэрээнд заасан ажлын даалгаврын дагуу ажлын тайлан бичигдээгүй, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэл нотлох баримтаар дэмжигдээгүй зөрчилд тогтоосон төлбөр акт төлөгдөөгүй;
- Хилийн боомтын захиргааны үндсэн цалинг тогтоох цалингийн шатлал хууль, эрх зүйн орчин бүрэн бүрдээгүйгээс шалтгаалан аль цалингийн шатлалд хамаарах эсэх талаар тодорхой ажил хийгдээгүй, шийдвэр гараагүй;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, хуулиар хязгаарласан зардлыг санхүүжүүлж, тайлант онд 57 ширхэг 10,296.4 мянган төгрөгийг ноолууран цамц, ороолт, малгай зэрэг бэлэг дурсгалын зүйл худалдан авахад зарцуулсан;
- Өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх 153 мэдээллээс 15 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн ба 25 мэдээллийг мэдээлээгүй байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 231,799.3 мянган төгрөгийн зарлагын 2 гүйлгээг мэдээлээгүй, 1,233,609.6 мянган төгрөгийн орлогын 7 гүйлгээ, 893,389.6 мянган төгрөгийн зарлагын 57 гүйлгээг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн;

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант оны аудитаар илэрсэн анхаарал татсан дараах асуудлуудад дараагийн аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

1. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:
    - Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны finperform.mof.gov.mn сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах.
    - Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг дээрх Сангийн яамны шинэ сайттай уялдуулах.
2. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тайлант онд 4,906,790.0 мянган төгрөгөөр тооцож, тайлагнасан байна. Энэ нь УСНББОУС-ын дагуу тооцсон эсэх, хөрөнгийн ашиглах жилийг бодит хугацаагаар бүртгэсэн эсэх, боомтуудын үйл ажиллагаанд ашиглуулахаар шилжүүлэн өгч байгаа хөрөнгөнд хяналтын тооллого хийх гэх мэт.

3. Тайлант оны батлагдсан төсвийг 12,180,584.2 мянган төгрөгөөр тодотгосоныг жилийн эцэст 10,412,950.1 мянган төгрөгийг зарцуулахаар төсвийн хуваарийг шинэчилсэн байгааг Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитаар анхаарч үзэх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8,448,618.2 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Бараа материалын товчоо тайлангийн үлдэгдэл нь санхүүгийн байдлын тайлангийн бараа материалын үлдэгдлээс 106.0 мянган төгрөгөөр зөрүүтэй;
- Бараа материалын дансанд бүртгэгдэх 5,524.0 мянган төгрөгийн материалыг сэлбэг хэрэгсэл гэсэн нэршлээр бараа материалын данснаас зарлагадсан;
- Санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүн 5,524.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн бусад орлого дансанд тайлагнах 19,000.0 мянган төгрөгийн автомашины дуудлага худалдааны төлбөрийн орлогыг урсгал санхүүжилтийн орлогоор тайлагнасан;
- Санхүүгийн тайлангийн бараа материалын үлдэгдэл нь бараа материалын тодруулга тайлангаас 250.0 мянган төгрөгөөр зөрүүтэй;
- Урсгал засварын зардалд тайлагнах 1,490.7 мянган төгрөгийн зардлыг бараа материалын дансанд бүртгэсэн;
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал санхүүжилтийн орлогыг 4,555.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайлангийн багаж, техник хэрэгслийн зардлын эхний үлдэгдэл 6,673.0 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн үйлчилгээний зардлын эхний үлдэгдэл 24,020.2 мянган төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлын эцсийн үлдэгдэл 16,436.0 мянган төгрөгөөр дутуу;
- Мөнгөн гүйлгээний тайланд урсгал санхүүжилтийг 4,175,510.6 мянган төгрөгөөр, төвлөрүүлэх шилжүүлгийг 4,189,527.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;

Аудитаар нийт 2,378,744.1 мянган төгрөгийн 11 зөрчил[2] илэрснээс, 11,074.7 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 596,574,7 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага, 27,796.4 мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 1 албан шаардлагыг тус тус хүргүүлж, 1,743,298.3 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,378,744.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,275,264.0 мянган төгрөгөөр давсан тул  Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

<u>*Илрүүлэлт 1:*</u> Тайлант онд 6 ажилтны 4,713.9 мянган төгрөгийн цалинг ээлжийн амралтын олговортой давхардуулан олгосон, 4 ажилтны ээлжийн амралтын хоногийг зөрүүтэй тооцсоноос 920.8 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн  5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “Үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралт "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

цалин тооцох журам"-ын 2.13-т "Ажилтны ажилласан хугацааг харгалзан ээлжийн нэмэгдэл амралтыг дор дурдсанаар тооцож олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Илүү олгосон ээлжийн амралтын олговрыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

*Илрүүлэлт 2:* Тайлант оны 1-10 саруудад нийт 28 ажилтанд ажиллаагүй хоногт ногдох 5,440.0 мянган төгрөгийн хоол, унааны нэмэгдлийг тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “Үнэн зөв байх”, 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:" 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Илүү олгосон хоол, унааны нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

*Илрүүлэлт 1:* Өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй дараах зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд:

- "Блэссэд софтвейр ХХК-тай Вебсайт хөгжүүлэх зөвлөх үйлчилгээний 17,500.0 мянган төгрөгийн гэрээг байгуулсан боловч гэрээнд заасан ажлын даалгаврын дагуу ажлын тайлан бичигдээгүй, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэл нотлох баримтаар дэмжигдээгүй зөрчилд тогтоосон төлбөр акт төлөгдөөгүй;
- Хилийн боомтын захиргааны үндсэн цалинг тогтоох цалингийн шатлал хууль, эрх зүйн орчин бүрэн бүрдээгүйгээс шалтгаалан аль цалингийн шатлалд хамаарах эсэх талаар тодорхой ажил хийгдээгүй, шийдвэр гараагүй;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, хуулиар хязгаарласан зардлыг санхүүжүүлж, тайлант онд 57 ширхэг 10,296.4 мянган төгрөгийг ноолууран цамц, ороолт, малгай зэрэг бэлэг дурсгалын зүйл худалдан авахад зарцуулсан.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй албан тушаалтанд Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

*Илрүүлэлт 2:* Хилийн боомтын төлөөлөгчийн албан хэрэгцээнд зориулан тайлант онд шинээр худалдан авсан 160,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий 1 тээврийн хэрэгслийг дээд газраас ирсэн чиглэлийн дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 11 дүгээр сарын 09-ний өдрийн 549 дүгээр тогтоолыг үндэслэн Үндэсний урлагийн их театрын хэрэгцээнд шилжүүлж өөрийн хэрэгцээ шаардлагаас давсан хөрөнгө бэлтгэж батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “үр ашигтай байх”, 4.1.9-д “хариуцлагатай байх” гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө бэлтгэж, үр ашиггүй зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

*Илрүүлэлт 3:* Тайлант хугацаанд 162,849.7 мянган төгрөгийн шатахуун зарцуулахдаа шатахууныг нормын дагуу бодоогүй, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, мөн бараа материалын дансанд бүртгэхдээ тоо ширхэг, нэгж өртгийг алдаатай буюу нэг бүрийн үнийг 1 төгрөгөөр тооцож бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т үнэн зөв байх" 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Шатахууныг бодит үнэ цэнээр бүртгээгүй, зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

*Илрүүлэлт 4:* Тус байгууллага нь балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт гаргаж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хөрөнгийн нэр төрөл, үнийн дүнг тооцооллын алдаатай хүргүүлснээс Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 16 дугаар тогтоолоос хөрөнгийг 179,292.0 мянган төгрөгөөр зөрүүтэйгээр шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, ТӨБЗГ-ын 2025 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 16 дугаар тогтоол”-д заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Дээд газрын шийдвэрээс зөрүүтэй дүнгээр хөрөнгө шилжүүлсэн зөрчлийг таслан зогсоож албан шаардлага хүргүүлэв.

*Илрүүлэлт 5:* Албан томилолтын төсвийн тооцооллыг батлагдсан тушаалын дагуу хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй нийт 94,433.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Анхан шатны баримтын бүрдэлгүй томилолтын зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож албан шаардлага хүргүүлэв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт 1:* Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой нийт 91 ширхэг 675,723.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ

байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", Компанийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.3.1.8 дахь заалтад "Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн зах зээлийн үнийг тогтоох, данснаас хасах" гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой хөрөнгийг холбогдох журмын дагуу үнэлж бүртгэлд тусгах

*Илрүүлэлт 2:* Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд 61 нэр төрлийн 1,053,507.9 мянган төгрөгийн хөрөнгийг гадаад нэршлээр бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нь нягтлан бодох бүртгэлээ монгол хэлээр хөтөлнө" гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Хөрөнгийн нэршлийг монгол хэлээр болгон өөрчилж, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Цалин хөлсний бүртгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт 1:* Тайлант онд 14 ажилтны олговол зохих цалинг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 6,765.5 мянган төгрөгөөр дутуу, 1,662.5 мянган төгрөгөөр илүү тооцож зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө” гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Ажилчдын цалин хөлсийг үнэн зөв, зөрүүгүйгээр татвар болон нийгмийн даатгалд тайлагнаж байх

*Илрүүлэлт 2:* Гэрээт ажлын төлбөр болох 40,000.0 мянган төгрөгийг олгохдоо нийгмийн даатгалын шимтгэлийн 1,821.6 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварын 3,817.8 мянган төгрөгийг суутгаж тайлагнаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүн, 19.1.4.үндсэн ажлаас бусад хуулийн этгээд, хүнээс олгосон энэ хуулийн 19.1.1-д заасан цалин хөлс, олговор; Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн Албан татвар ногдох орлогод 7 дугаар зүйлийн 7.1.5 “гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого” гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Хувь хүнд олгох гэрээт ажлын төлбөрөөс холбогдох хууль дүрэм журмын дагуу суутгалыг хийж, төсөвт төвлөрүүлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Бараа материалын товчоо тайлангийн үлдэгдэл нь санхүүгийн байдлын тайлангийн бараа материалын үлдэгдлээс 106.0 мянган төгрөгөөр зөрүүтэй | 1 | 106.0 | | | 1 | 106.0 | 1 | 106.0 | | | | |
| 2 | Бараа материалын дансанд бүртгэгдэх 5,524.0 мянган төгрөгийн материалыг сэлбэг хэрэгсэл гэсэн нэршлээр бараа материалын данснаас зарлагадсан | 1 | 5,524.0 | | | 1 | 5,524.0 | 1 | 5,524.0 | | | | |
| 3 | Санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүн 5,524.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 5,524.0 | | | 1 | 5,524.0 | 1 | 5,524.0 | | | | |
| 4 | Санхүүгийн үр дүнгийн тайлангийн бусад орлого дансанд тайлагнах 19,000.0 мянган төгрөгийн автомашины дуудлага худалдааны төлбөрийн орлогыг урсгал санхүүжилтийн орлогоор тайлагнасан | 1 | 19,000.0 | | | 1 | 19,000.0 | 1 | 19,000.0 | | | | |
| 5 | Санхүүгийн тайлангийн бараа материалын үлдэгдэл нь бараа материалын тодруулга тайлангаас 250.0 мянган төгрөгөөр зөрүүтэй | 1 | 250.0 | 1 | 250.0 | | | 1 | 250.0 | | | | |
| 6 | Урсгал засварын зардалд тайлагнах 1,490.7 мянган төгрөгийн зардлыг бараа материалын дансанд бүртгэсэн | 1 | 1,490.7 | | | 1 | 1,490.7 | 1 | 1,490.7 | | | | |
| 7 | Санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал санхүүжилтийн орлогыг 4,555.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан | 1 | 4,555.8 | | | 1 | 4,555.8 | 1 | 4,555.8 | | | | |
| 8 | Мөнгөн гүйлгээний тайлангийн багаж, техник хэрэгслийн зардлын эхний үлдэгдэл 6,673.0 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн үйлчилгээний зардлын эхний үлдэгдэл 24,020.2 мянган төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлын эцсийн үлдэгдэл 16,436.0 мянган төгрөгөөр дутуу | 1 | 47,129.2 | 1 | 47,129.2 | | | 1 | 47,129.2 | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Мөнгөн гүйлгээний тайланд урсгал санхүүжилтийг 4,175,510.6 мянган төгрөгөөр, төвлөрүүлэх шилжүүлгийг 4,189,527.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан | 1 | 8,365,038.5 | | | 1 | 8,365,038.5 | 1 | 8,365,038.5 | | | | |
| | **Дүн** | **9** | **8,448,618.2** | **2** | **47,379.2** | **7** | **8,401,239.0** | **9** | **8,448,618.2** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцох албан шаардлага | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Тайлант онд 6 ажилтны 4,713.9 мянган төгрөгийн цалинг ээлжийн амралтын олговортой давхардуулан олгосон, 4 ажилтны ээлжийн амралтын хоногийг зөрүүтэй тооцсоноос 920.8 мянган төгрөгийг илүү олгосон байна. | 1 | 5,634.7 | 1 | 5,634.7 | | | | | | |
| 2 | Тайлант оны 1-10 саруудад нийт 28 ажилтанд ажиллаагүй хоногт ногдох 5,440.0 мянган төгрөгийн хоол, унааны нэмэгдлийг тооцож олгосон байна. | 1 | 5,440.0 | 1 | 5,440.0 | | | | | | |
| 3 | Хилийн боомтын төлөөлөгчийн албан хэрэгцээнд зориулан тайлант онд шинээр худалдан авсан 160,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий 1 тээврийн хэрэгслийг дээд газраас ирсэн чиглэлийн дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 11 дүгээр сарын 09-ний өдрийн 549 дүгээр тогтоолыг үндэслэн Үндэсний урлагийн их театрын хэрэгцээнд шилжүүлж өөрийн хэрэгцээ шаардлагаас давсан хөрөнгө бэлтгэж батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна. | 1 | 160,000.0 | | | 1 | 160,000.0 | | | | |
| 4 | Тайлант хугацаанд 162,849.7 мянган төгрөгийн шатахуун зарцуулахдаа шатахууныг нормын | 1 | 162,849.7 | | | 1 | 162,849.7 | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дагуу бодоогүй, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, мөн бараа материалын дансанд бүртгэхдээ тоо ширхэг, нэгж өртгийг алдаатай буюу нэг бүрийн үнийг 1 төгрөгөөр тооцож бүртгэсэн байна. | | | | | | | | | | |
| 5 | Тус байгууллага нь балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт гаргаж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хөрөнгийн нэр төрөл, үнийн дүнг тооцооллын алдаатай хүргүүлснээс Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 16 дугаар тогтоолоос хөрөнгийг 179,292.0 мянган төгрөгөөр зөрүүтэйгээр шилжүүлсэн байна. | 1 | 179,292.0 | | | 1 | 179,292.0 | | | | |
| 6 | Албан томилолтын төсвийн тооцооллыг батлагдсан тушаалын дагуу хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй нийт 94,433.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна. | 1 | 94,433.0 | | | 1 | 94,433.0 | | | | |
| 7 | Өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй дараах зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд:<br>"Блэссэд софтвейр ХХК-тай Вебсайт хөгжүүлэх зөвлөх үйлчилгээний 17,500.0 мянган төгрөгийн гэрээг байгуулсан боловч гэрээнд заасан ажлын даалгаврын дагуу ажлын тайлан бичигдээгүй, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэл нотлох баримтаар дэмжигдээгүй зөрчилд тогтоосон төлбөр акт төлөгдөөгүй;<br>Хилийн боомтын захиргааны үндсэн цалинг тогтоох цалингийн шатлал хууль, эрх зүйн орчин бүрэн бүрдээгүйгээс шалтгаалан аль цалингийн шатлалд хамаарах эсэх талаар тодорхой ажил хийгдээгүй, шийдвэр гараагүй;<br>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, хуулиар хязгаарласан зардлыг санхүүжүүлж, тайлант онд 57 ширхэг | 1 | 27,796.4 | | | | | | | 1 | 27,796.4 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 10,296.4 мянган төгрөгийг ноолууран цамц, ороолт, малгай зэрэг бэлэг дурсгалын зүйл худалдан авахад зарцуулсан. | | | | | | | | | | |
| 8 | Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой нийт 91 ширхэг 675,723.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна. | 1 | 675,723.0 | | | | | 1 | 675,723.0 | | |
| 9 | Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд 61 нэр төрлийн 1,053,507.9 мянган төгрөгийн хөрөнгийг гадаад нэршлээр бүртгэсэн байна. | 1 | 1,053,507.9 | | | | | 1 | 1,053,507.9 | | |
| 10 | Тайлант онд 14 ажилтны олговол зохих цалинг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 6,765.5 мянган төгрөгөөр дутуу, 1,662.5 мянган төгрөгөөр илүү тооцож зөрүүтэй тайлагнасан байна. | 1 | 8,428.0 | | | | | 1 | 8,428.0 | | |
| 11 | Гэрээт ажлын төлбөр болох 40,000.0 мянган төгрөгийг олгохдоо нийгмийн даатгалын шимтгэлийн 1,821.6 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварын 3,817.8 мянган төгрөгийг суутгаж тайлагнаагүй байна. | 1 | 5,639.4 | | | | | 1 | 5,639.4 | | |
| | **Дүн** | **11** | **2,378,744.1** | **2** | **11,074.7** | **4** | **596,574.7** | **4** | **1,743,298.3** | **1** | **27,796.4** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 1 | Өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх 153 мэдээллээс 15 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн, 25 мэдээллийг мэдээлээгүй байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 удаагийн 231,799.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй, 1,233,609.6 мянган төгрөгийн орлогын 7 гүйлгээ, 893,389.6 мянган төгрөгийн зарлагын 57 гүйлгээг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | 2,358,798.5 | | | 1 | 2,358,798.5 | | |
| | **Дүн** | **1** | **2,358,798.5** | | | **1** | **2,358,798.5** | | |
| | Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| 1 | Нээлттэй тендер сонгон шалгаруулалтын үнэлгээний хороо тушаалын дагуу хурал зохион байгуулж тендерийн баримт бичиг боловсруулж, зарлах байтал хуралдаагүй, ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл үйлдээгүй, гэрээ байгуулахдаа огноог тодорхойлоогүй, тендерийн баримт бичгийг хуулийн дагуу архивлаагүй зэрэг зөрчилтэй байна. | 1 | | 1 | | | | | |
| | **Дүн** | **1** | | **1** | | | | | |
| | **Нийт дүн** | **2** | **2,358,798.5** | **1** | | **1** | **2,358,798.5** | | |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АКТ**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 73/A0150061 Улаанбаатар хот

САГ-2026/256/ИА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хилийн боомтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 1-10 саруудад хавсралтад дурдсан нийт 28 ажилтанд ажиллаагүй хоногт ногдох 5,440,000.00 /таван сая дөрвөн зуун дөчин мянган/ төгрөгийн хоол, унааны нэмэгдлийг тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “Үнэн зөв байх”, 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:" 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.
Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хавсралтад дурдсан 49 албан хаагчид илүү тооцож олгосон 5,440,000.00 /таван сая дөрвөн зуун дөчин мянган/ төгрөгийг Хилийн боомтын захиргааны дарга /Б.Батхишиг/-ээр нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн яамны дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалт, үнэлгээний газрын дарга /Ж.Цогтбаяр/-т хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР П.ЧАНЦАЛДУЛАМ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Т.ОДОНЧИМЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АКТ**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 72/А0150061 Улаанбаатар хот

САГ-2026/256/НА-СТА-ТШ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хилийн боомтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд хавсралтад дурдсан 6 ажилтны 4,713,910.00 /дөрвөн сая долоон зуун арван гурван мянга есөн зуун арван/ төгрөгийн цалинг ээлжийн амралтын олговортой давхардуулан олгосон, 4 ажилтны ээлжийн амралтын хоногийг зөрүүтэй тооцсоноос 920,793.00 /есөн зуун хорин мянга долоон зуун ерэн гурван/ төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “Үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.*”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;*”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралт "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.13-т "Ажилтны ажилласан хугацааг харгалзан ээлжийн нэмэгдэл амралтыг дор дурдсанаар тооцож олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хавсралтад дурдсан 10 албан хаагчид илүү тооцож олгосон 5,634,703.00 /таван сая зургаан зуун гучин дөрвөн мянга долоон зуун гурван/ төгрөгийг Хүний нөөц, дотоод үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Одонтуяа/, Санхүү аж ахуйн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Я.Дүгэржав/ нараар нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хилийн боомтын захиргааны дарга /Б.Батхишиг/-т хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР П.ЧАНЦАЛДУЛАМ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Т.ОДОНЧИМЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 363/А0150061 Улаанбаатар хот

САГ-2026/256/ИА-СТА-ТГИЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хилийн боомтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй дараах зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд:

- "Блэссэд софтвейр ХХК-тай Вебсайт хөгжүүлэх зөвлөх үйлчилгээний 17,500,000.00 /арван долоон сая таван зуун мянган/ төгрөгийн гэрээг байгуулсан боловч гэрээнд заасан ажлын даалгаврын дагуу ажлын тайлан бичигдээгүй, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэл нотлох баримтаар дэмжигдээгүй зөрчилд тогтоосон төлбөр акт төлөгдөөгүй;
- Хилийн боомтын захиргааны үндсэн цалинг тогтоох цалингийн шатлал хууль, эрх зүйн орчин бүрэн бүрдээгүйгээс шалтгаалан аль цалингийн шатлалд хамаарах эсэх талаар тодорхой ажил хийгдээгүй, шийдвэр гараагүй;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, хуулиар хязгаарласан зардлыг санхүүжүүлж, тайлант онд 57 ширхэг 10,296,390.00 /арван сая хоёр зуун ерэн зургаан мянга гурван зуун ерэн/ төгрөгийг ноолууран цамц, ороолт, малгай зэрэг бэлэг дурсгалын зүйл худалдан авахад зарцуулсан.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй Санхүү аж ахуйн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Я.Дугэржав/-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хилийн боомтын захиргааны дарга /Б.Батхишиг/-т даалгав

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | П.ЧАНЦАЛДУЛАМ |
| МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ | Т.ОДОНЧИМЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-63.Docx

1526180794

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 364/А0150061 Улаанбаатар хот

САГ - 2026/1256/НА - СТА-ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хилийн боомтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд Шилэн дансны цахим хуудсанд мэдээллэх 153 мэдээллээс 15 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн,25 мэдээллийг мэдээллээгүй байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 удаагийн 231,799,319.00 /хоёр зуун гучин нэгэн сая долоон зуун ерэн есөн мянга гурван зуун арван есөн/ төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээллээгүй, 1,233,609,600.00 /нэг тэрбум хоёр зуун гучин гурван сая зургаан зуун есөн мянга зургаан зуун/ төгрөгийн орлогын 7 гүйлгээ, 893,389,608.00 /найман зуун ерэн гурван сая гурван зуун наян есөн мянга зургаан зуун найман/ төгрөгийн зарлагын 57 гүйлгээг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй Санхүү, дотоод аудит, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн /С.Солонго/-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хилийн боомтын захиргааны дарга /Б.Батхишиг/-т даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР П.ЧАНЦАЛДУЛАМ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Т.ОДОНЧИМЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

*Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-63.Docx*

1526100798

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 365/А0150061 Улаанбаатар хот

САГ-2026/256/ИА-СТА-ТШ3

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хилийн боомтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нээлттэй тендер сонгон шалгаруулалтын үнэлгээний хороо тушаалын дагуу хурал зохион байгуулж тендерийн баримт бичиг боловсруулж, зарлах байтал хуралдаагүй, ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл үйлдээгүй, гэрээ байгуулахдаа огноог тодорхойлоогүй, тендерийн баримт бичгийг хуулийн дагуу архивлаагүй зэрэг зөрчилтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана", 48 дугаар зүйлийн 48.4-т "Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдүүлж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана", 50 дугаар зүйлийн 50.2-т "Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ", 50.2.1-т тендер шалгаруулалтын баримт бичиг, зарлал, урилга боловсруулах, тендер хүлээн авах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тендерийн баримт бичгийг хуулийн дагуу бүрдүүлдэггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хилийн боомтын захиргааны дарга /Б.Батхишиг/, Санхүү аж ахуйн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Я.Дүгэржав/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР П.ЧАНЦАЛДУЛАМ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Т.ОДОНЧИМЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-63.Docx

1526180806

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 366/А0150061 Улаанбаатар хот

САГ-2026/256/ИА-СТА-ТШ3

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хилийн боомтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан томилолтын төсвийн тооцооллыг батлагдсан тушаалын дагуу хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй нийт 94,432,960.00 /ерэн дөрвөн сая дөрвөн зуун гучин хоёр мянга есөн зуун жаран/ төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй томилолтын зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хилийн боомтын захиргааны дарга /Б.Батхишиг/, Санхүү аж ахуйн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Я.Дугэржав/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР П.ЧАНЦАЛДУЛАМ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Т.ОДОНЧИМЭГ

9005109
АТА16087
2025001411

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-63.Docx

1526180804

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 367/А0150061 Улаанбаатар хот

САГ-2026/256/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хилийн боомтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт гаргаж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хөрөнгийн нэр төрөл, үнийн дүнг тооцооллын алдаатай хүргүүлснээс Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 16 дугаар тогтоолоос хөрөнгийг 179,292,000.00 /нэг зуун далан есөн сая хоёр зуун ерэн хоёр мянган/ төгрөгөөр зөрүүтэйгээр шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", ТӨБЗГ-ын 2025 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 16 дугаар тогтоол"-д заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээд газрын шийдвэрээс зөрүүтэй дүнгээр хөрөнгө шилжүүлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хилийн боомтын захиргааны дарга /Б.Батхишиг/, Санхүү аж ахуйн хэлтэсийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Я.Дүгэржав/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР П.ЧАНЦАЛДУЛАМ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Т.ОДОНЧИМЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-63.Docx

1526180800

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 368/А0150061 Улаанбаатар хот

САГ-2026/1256/НА-СТА-ТШ3

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хилийн боомтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хилийн боомтын төлөөлөгчийн албан хэрэгцээнд зориулан тайлант онд шинээр худалдан авсан 160,000,000.00 /нэг зуун жаран сая/ төгрөгийн өртөг бүхий 1 тээврийн хэрэгслийг дээд газраас ирсэн чиглэлийн дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 11 дүгээр сарын 09-ний өдрийн 549 дүгээр тогтоолыг үндэслэн Үндэсний урлагийн их театрын хэрэгцээнд шилжүүлж өөрийн хэрэгцээ шаардлагаас давсан хөрөнгө бэлтгэж батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “үр ашигтай байх”, 4.1.9-д “хариуцлагатай байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө бэлтгэж, үр ашиггүй зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хилийн боомтын захиргааны дарга /Б.Батхишиг/, Санхүү аж ахуйн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Я.Дүгэржав/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР П.ЧАНЦАЛДУЛАМ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Т.ОДОНЧИМЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 369/А0150061 Улаанбаатар хот

САГ-2026/256/НА-СТА-ТШ3

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хилийн боомтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 162,849,750.00 /нэг зуун жаран хоёр сая найман зуун дөчин есөн мянга долоон зуун тавин/ төгрөгийн шатахуун зарцуулахдаа шатахууныг нормын дагуу бодоогүй, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, мөн бараа материалын дансанд бүртгэхдээ тоо ширхэг, нэгж өртгийг алдаатай буюу нэг бүрийн үнийг 1 төгрөгөөр тооцож бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т үнэн зөв байх" 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-т “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шатахууныг бодит үнэ цэнээр бүртгээгүй, зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хилийн боомтын захиргааны дарга /Б.Батхишиг/, Санхүү аж ахуйн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч /Я.Дүгэржав/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР П.ЧАНЦАЛДУЛАМ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Т.ОДОНЧИМЭГ

9006109
АТА16007
9025081411

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-63.Docx

1526180798